

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/222/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БОРНУУР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2026 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор: Б.Адъяасүрэн

Утас: 70273204 Цахим хаяг: adiyasurenb@audit.gov.mn

Гэрээгээр гүйцэтгэсэн:

Уваа уул аудит ХХК, захирал: Ч.Мөнхтуяа

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2026.02.25 № 01/179
танай _____ -ны № _____ -т

ТӨВ АЙМГИЙН БОРНУУР
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Х.ЭНХТУЯА
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 254 дүгээр тогтоолоор Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн хүүхдийн нэг өдрийн үдийн хоолны түүхий эдийн зардлыг 2.5 мянган төгрөг, дотуур байранд амьдрах дунд болон ахлах ангийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 6.3 мянган төгрөг, бага ангийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 6.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон байна.

Аудитын гол асуудал

Төв аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 34,000.0 мянган төгрөг, Борнуур сумын Засаг даргын нөөцөөс хөрөнгөөс 10,000.0 мянган төгрөг, нийт 44,000.0 мянган төгрөгийн санхүүжилтээр тус сургуульд “Бүрд оргих дриллинг” ХХК-наар гүний худаг гаргуулж, нэн шаардлагатай цэвэр усны асуудлыг шийдвэрлэсэн.

Бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Засаг даргын Тамгын газраас орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Хүүхдийн автобус хөтөлбөр”-ын хүрээнд ТӨАХААГ/20240102068

4126020153

Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

дугаартай худалдан авах ажиллагааг зохион байгуулж, "Хаштехник" ХХК шалгарч нэг бүр нь 57,497.0 мянган төгрөгийн өртөгтэй БНХАУ-д үйлдвэрлэсэн хүүхдийн шар автобусыг 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдөр хүлээлгэн өгсөн.

Хүүхдийн шар автобусны суудлын хэмжээ нь бага ангийн сурагч суух боломжгүй жижиг, техникийн шаардлага хангахгүй, эвдрэлтэй байсан тул Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургууль нь замын хөдөлгөөнд оролцуулаагүй байна.

Тус байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт бүхий нийт 45 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 98,3 хувиар үнэлэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБООУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	735,810,769.70	761,634,085.39
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	559,429,601.33	562,014,971.27
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	559,429,601.33	562,014,971.27
3121	Төгрөг	559,429,601.33	562,014,971.27
31211	Төрийн сангийн харилцах	559,429,601.33	562,014,971.27
33	АВЛАГА	-	3,272,975.90
335	Бусад авлага	-	3,272,975.90
35	БАРАА МАТЕРИАЛ	176,381,168.37	196,346,138.22
354	Хангамжийн материал	104,691,740.53	124,656,710.38
35410	Бичиг хэргийн материал	24,060.00	-
35420	Аж ахуйн материал	39,420,095.32	39,420,095.32
35430	Сэлбэг хэрэгсэл	63,208,866.21	83,917,696.06
35440	Түлш, шатах тослох материал	1,211,219.00	1,195,919.00
35450	Барилгын засварын материал	5,500.00	-
35460	Хүнсний материал	-	123,000.00
35470	Бусад хангамжийн материал	822,000.00	-
35600	Мал амьтад	71,689,427.84	71,689,427.84
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,037,607,594.34	1,199,118,264.56
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,037,607,594.34	1,199,118,264.56
392	Биет хөрөнгө	997,887,594.34	1,094,172,264.56
39201	Барилга, байгууламж, орон сууц	945,414,246.25	945,414,246.25
39202	Хуримтлагдсан элэгдэл	(337,592,474.32)	(373,672,425.88)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	71,997,000.00	71,997,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(7,241,616.49)	(20,191,016.41)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	395,005,091.51	429,397,166.26
39206	Хуримтлагдсан элэгдэл	(191,920,205.69)	(118,394,460.75)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	223,057,167.77	202,146,993.15
39208	Хуримтлагдсан элэгдэл	(121,999,431.19)	(60,475,352.26)
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,520,000.00	5,520,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,288,000.00)	(1,840,000.00)
39217	Ном	16,935,816.50	14,270,114.20
393	Биет бус хөрөнгө	39,720,000.00	104,946,000.00
39301	Програм хангамж	1,010,000.00	1,010,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,010,000.00)	(1,010,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	39,720,000.00	104,946,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,773,418,364.04	1,960,752,349.95
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,346,100.00	17,629,045.17
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,346,100.00	17,629,045.17
413	Өглөг	2,346,100.00	17,629,045.17
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	132,600.00	-

**Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	15,267,145.17
4136	Бусад өглөг	2,213,500.00	2,361,900.00
41361	Байгууллагад төлөх өглөг	2,213,500.00	2,361,900.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,771,072,264.04	1,943,123,304.78
51	Засгийн газрын хувь оролцоо	1,771,072,264.04	1,943,123,304.78
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	536,197,162.35	601,423,162.35
51101	Өмч: - төрийн	536,197,162.35	601,423,162.35
512	Хуримтлагдсан үр дүн	459,052,017.61	565,877,058.35
51210	Өмнөх үеийн үр дүн	459,052,017.61	466,520,045.05
51220	Тайлант үеийн үр дүн	-	99,357,013.30
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	775,823,084.08	775,823,084.08
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,773,418,364.04	1,960,752,349.95

Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,896,992,137.34	3,302,511,056.13
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	164,512,284.34	194,487,456.13
120	Нийтлэг татварын бус орлого	164,512,284.34	192,557,456.13
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,289,507.00	8,246,850.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	379,000.00	6,027,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,910,507.00	2,219,150.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	149,391,151.44	150,158,776.28
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	11,831,625.90	34,151,829.85
122	Тусламжийн орлого	-	1,930,000.00
122002	Хандив тусламж /гадаад/	-	1,930,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,732,479,853.00	3,108,023,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,517,236,300.00	2,880,477,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,517,236,300.00	2,880,477,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	215,243,553.00	227,546,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	215,243,553.00	227,546,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,558,774,450.26	3,203,154,042.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,558,774,450.26	3,203,154,042.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,475,850,850.26	3,096,614,442.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,769,136,341.57	2,203,947,606.54
210101	Үндсэн цалин	1,204,602,275.71	1,351,984,256.99
210102	Нэмэгдэл	534,391,515.86	792,587,156.67
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	14,351,505.61
210104	Урамшуулал	30,142,550.00	45,024,687.27
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	215,296,279.57	271,347,523.21
210201	Тэтгэврийн даатгал	145,885,059.64	191,121,963.55
210202	Тэтгэмжийн даатгал	18,451,935.75	20,456,696.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,709,434.35	10,379,967.56
210204	Ажилгүйдлийн даатгал	8,294,803.91	9,877,859.23
210205	Эрүүл мэндийн даатгал	33,955,045.92	39,511,036.87
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	212,355,103.00	223,647,445.17
210301	Гэрэл, цахилгаан	10,070,705.67	16,902,741.17
210302	Түлш, халаалт	197,059,548.00	201,252,304.00
210303	Цэвэр, бохир ус	5,224,849.33	5,492,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,379,170.00	41,373,251.30
210401	Бичиг хэрэг	17,650,450.00	16,493,960.00
210402	Тээвэр, шатахуун	8,728,720.00	6,568,339.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	3,352,650.00
210404	Ном, хэвлэл	-	2,665,702.30
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	645,000.00

**Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	11,647,600.00
2105	Нормативт зардал	112,510,347.00	132,362,110.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	98,000.00
210502	Хоол, хүнс	85,027,490.00	131,442,110.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	27,482,857.00	822,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,500,000.00	29,975,370.00
210604	Урсгал засвар	2,500,000.00	29,975,370.00
2107	Томилолт, зочны зардал	-	10,868,500.00
210702	Дотоод албан томилолт	-	10,868,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,084,442.86	37,203,082.85
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	6,027,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	1,152,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	78,850.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	19,084,442.86	29,944,532.85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,803,312.82	5,267,150.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	7,640,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	87,785,853.44	132,982,403.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	82,923,600.00	106,539,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	82,923,600.00	106,539,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	82,923,600.00	106,539,600.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	338,217,687.08	99,357,013.30
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	162,597,476.85	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	162,597,476.85	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(162,597,476.85)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	175,620,210.23	99,357,013.30

Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,735,769,360.00	3,116,270,450.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,289,507.00	8,246,850.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,289,507.00	8,246,850.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,289,507.00	8,246,850.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	379,000.00	6,027,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,910,507.00	2,219,150.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,732,479,853.00	3,108,023,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,517,236,300.00	2,880,477,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,517,236,300.00	2,880,477,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	215,243,553.00	227,546,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	215,243,553.00	227,546,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,465,634,301.82	3,064,636,080.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,465,634,301.82	3,064,636,080.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,384,066,701.82	2,944,908,580.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,762,024,573.91	2,205,048,555.00
210101	Үндсэн цалин	1,205,037,649.74	1,353,085,205.45
210102	Нэмэгдэл	526,844,374.17	792,587,156.67
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	14,351,505.61
210104	Урамшуулал	30,142,550.00	45,024,687.27
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	222,275,447.23	271,747,273.21
210201	Тэтгэврийн даатгал	154,002,278.65	191,521,713.55
210202	Тэтгэмжийн даатгал	17,297,116.98	20,456,696.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,709,434.85	10,379,967.56
210204	Ажилгүйдлийн даатгал	8,311,570.83	9,877,859.23
210205	Эрүүл мэндийн даатгал	33,955,045.92	39,511,036.87
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	212,355,103.00	222,546,400.00
210301	Гэрэл, цахилгаан	10,070,705.67	16,294,000.00
210302	Түлш, халаалт	197,059,548.00	201,217,700.00
210303	Цэвэр, бохир ус	5,224,849.33	5,034,700.00
2105	Нормативт зардал	78,933,895.00	118,963,510.00
210502	Хоол, хүнс	78,933,895.00	118,963,510.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,888,450.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	2,888,450.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,893,588.53	51,035,949.85
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	6,027,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	20,893,588.53	45,008,249.85
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	84,695,644.15	70,566,892.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	65,528,697.15	59,204,392.00

**Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,166,947.00	11,362,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	81,567,600.00	119,727,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	81,567,600.00	119,727,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	81,567,600.00	119,727,500.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	270,135,058.18	51,634,369.94
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	44,669,260.00	49,049,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	44,669,260.00	49,049,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	44,669,260.00	49,049,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	44,669,260.00	49,049,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(44,669,260.00)	(49,049,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	225,465,798.18	2,585,369.94
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	333,963,803.15	559,429,601.33
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	559,429,601.33	562,014,971.27

Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	536,197,162.35	775,823,084.08	283,431,807.38	1,595,452,053.81
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	536,197,162.35	775,823,084.08	283,431,807.38	1,595,452,053.81
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	175,620,210.23	175,620,210.23
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	536,197,162.35	775,823,084.08	459,052,017.61	1,771,072,264.04
2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	536,197,162.35	775,823,084.08	459,052,017.61	1,771,072,264.04
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	7,468,027.44	7,468,027.44
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	536,197,162.35	775,823,084.08	466,520,045.05	1,778,540,291.48
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	65,226,000.00	00.00	00.00	65,226,000.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	99,357,013.30	99,357,013.30
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	601,423,162.35	775,823,084.08	565,877,058.35	1,943,123,304.78

**Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,724,044,600.00	3,115,851,300.00	608,193,300.00	83.67
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,945,876,700.00	2,880,477,200.00	65,399,500.00	97.78
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,945,876,700.00	2,880,477,200.00	65,399,500.00	97.78
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	227,546,400.00	227,546,400.00	-	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	227,546,400.00	227,546,400.00	-	100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	550,621,500.00	7,827,700.00	542,793,800.00	1.42
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,027,700.00	7,827,700.00	(1,800,000.00)	129.86
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	544,593,800.00		544,593,800.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,724,044,600.00	3,113,265,930.06	610,778,669.94	83.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,724,044,600.00	3,113,265,930.06	610,778,669.94	83.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,578,880,200.00	2,993,538,430.06	585,341,769.94	83.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,684,947,800.00	2,205,048,555.00	479,899,245.00	82.13
210101	Үндсэн цалин	1,637,683,700.00	1,353,085,205.45	284,598,494.55	82.62
210102	Нэмэгдэл	991,630,400.00	792,587,156.67	199,043,243.33	79.93
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	14,351,505.61	(14,351,505.61)	
210104	Урамшуулал	55,633,700.00	45,024,687.27	10,609,012.73	80.93
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	335,618,400.00	271,480,123.21	64,138,276.79	80.89
210201	Тэтгэврийн даатгал	228,220,500.00	191,254,563.55	36,965,936.45	83.80
210202	Тэтгэмжийн даатгал	26,849,500.00	20,456,696.00	6,392,804.00	76.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,424,700.00	10,379,967.56	3,044,732.44	77.32
210204	Ажилгүйдлийн даатгал	13,424,700.00	9,877,859.23	3,546,840.77	73.58
210205	Эрүүл мэндийн даатгал	53,699,000.00	39,511,036.87	14,187,963.13	73.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	222,546,400.00	222,546,400.00	-	100.00
210301	Гэрэл, цахилгаан	16,294,000.00	16,294,000.00	-	100.00
210302	Түлш, халаалт	201,252,400.00	201,217,700.00	34,700.00	99.98
210303	Цэвэр, бохир ус	5,000,000.00	5,034,700.00	(34,700.00)	100.69
2105	Нормативт зардал	155,620,400.00	118,963,510.00	36,656,890.00	76.44
210502	Хоол, хүнс	155,620,400.00	118,963,510.00	36,656,890.00	76.44
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	51,954,700.00	51,035,949.85	918,750.15	98.23
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,027,700.00	6,027,700.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	45,927,000.00	45,008,249.85	918,750.15	98.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	123,192,500.00	119,463,892.00	3,728,608.00	96.97
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	108,251,400.00	104,701,392.00	3,550,008.00	96.72
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,941,100.00	14,762,500.00	178,600.00	98.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	145,164,400.00	119,727,500.00	25,436,900.00	82.48

**Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2132	Бусад урсгал шилжүүлэг	145,164,400.00	119,727,500.00	25,436,900.00	82.48
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	145,164,400.00	119,727,500.00	25,436,900.00	82.48
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		559,429,601.33		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		562,014,971.27		

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 1,389,746.1 мянган төгрөгийн алдаа илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Санхүүгийн үр дүнгийн тайланд үндсэн хөрөнгийн 1-9 дүгээр саруудын нийт 132,982.4 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг тайлагнаагүй.

Санхүүгийн үр дүнгийн болон мөнгөн гүйлгээний тайланд 164,250.4 мянган төгрөгийн орон нутгийн санхүүжилтийн орлогыг хандив тусламжийн орлогоор тайлагнасан.

Бараа материалын үнийн дүнгийн болон нэр төрлийн тайланг гаргаагүй, шаардах хуудсанд дарга, нягтлан бодогчийн зөвшөөрсөн гарын үсэг байхгүй, материал хүлээн авсан ажилтны гарын үсэггүйгээр 166,625.7 мянган төгрөгийн бараа материал зарлагдсан.

Санхүүгийн үр дүнгийн тайланд 277.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 8,869.5 мянган төгрөгийн бага үнэтэй түргэн элэгдэх зүйл, 8,304.6 мянган төгрөгийн урсгал засварын материалыг тус тус нормын хувцас зөөлөн эдлэлийн зардалд тайлагнасан.

Санхүүгийн үр дүнгийн тайланд 10,653.0 мянган төгрөгийн дотоод албан томилолтын зардлыг бусад зардлаар тайлагнасан.

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын Тамгын газраас санхүүжүүлсэн сургуулийн дотуур байрны уур сорогчийн Төв аймгийн орон нутгийн өмчийн газрын зөвшөөрөлгүй 13,614.0 мянган төгрөгийн хөрөнгийг сайжруулалтаар бүртгэсэн.

Тайлант онд 884,169.4 мянган төгрөгийн цалин хөлс, урамшлын зардлыг цалингийн өглөг дансанд бичилт хийлгүй бүртгэснийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна", 15.2-т "нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Аудитаар нийт 18,931.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 18,931.4 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 3 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 18,931.4 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 23,453.0 мянган төгрөгөөс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн "Хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 254 дүгээр тогтоолын дагуу тайланд онд суралцсан давхардсан 1-5 дугаар ангийн сурагчдын тоогоор 52,919 сурагчдад өдөр ногдох нормативаар тооцоход 132,297.5 мянган төгрөг, дотуур байранд байрладаг давхардсан тоогоор 19,408 сурагчдад ногдох нормативаар тооцоход 117,670.5 мянган төгрөгийг тус тус зарцуулахаас 231,036.6 мянган төгрөг зарцуулж 18,931.4 мянган төгрөгийг тус тус дутуу зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.4-т "Орон нутгийн төсвийн суурь зарлагыг тооцоох аргачлал, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх үйлчилгээний стандарт, тэдгээрийн орцын болон төсвийн нормативыг Засгийн газар тогтооно", Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн "Хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 254 дүгээр тогтоолын 1-т "ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн хүүхдийн нэг өдрийн үдийн хоолны түүхий эдийн зардлыг 2.5 мянган төгрөгөөр тогтоосугай" гэж заасныг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сурагчдын хоолны зардлыг батлагдсан нормативын дагуу тооцон олгох албан шаардлага өгөв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна", 8.1.5-д "Санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 8.3-д "Санхүүгийн тайлангийн тодруулга нь Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулаагүй боловч тэдгээрийн аль нэгийг ойлгоход хамааралтай нэмэлт мэдээллээр хангана" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланг тайлбар тодруулгын хамт бэлтгэж байх.

2. Зардлын дансны асуудалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр (81834), Хүүхэд хамгаалал хөтөлбөр (80233)-ийн бараа үйлчилгээний бусад зардлаас нийт 6,749.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Эдийн засгийн ангилал ашиглах заавар", Боловсролын сайдын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн "Заавар шинэчлэн батлах тухай" А/279 дүгээр тушаалаар баталсан "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд шаардлагатай сургалтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний нөхөн хангалтын зардлыг төлөвлөх, хуваарилах, санхүүжүүлэх аргачлал"-ын 3.1-т "Тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг Хүүхдэд ээлтэй сургалтын орчин зориулалтын (81816) хөтөлбөрийн бараа үйлчилгээний бусад зардал (210901)-эдийн засгийн ангилалд төлөвлөн хуваарилж, санхүүжүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хүүхдэд ээлтэй сургалтын орчин зориулалтын хөтөлбөрөөс үндсэн хөрөнгө бэлтгэж байх.

3. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 198 ширхэг 37,154.8 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй, холбогдох байгууллагад хүсэлт өгч шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" тухай 271 дүгээр тогтоолын 7.1-д "төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ", Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ" гэж тус тус заасантай нийцээгүй байна

Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгөнд тавих хяналтыг сайжруулж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох саналыг Төв аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж, шийдвэрлүүлэх.

4. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж 83,917.7 мянган төгрөгийн ном, сурах бичгийг сэлбэг хэрэгслийн дансанд, сургалтын хэрэглэгдэхүүнд ашиглагдаг 71,689.4 мянган төгрөгийн материалын мал амьтад дансанд бүртгэсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.6 “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын дансны ангилал залруулах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 20-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
								Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Санхүүгийн үр дүнгийн тайланд үндсэн хөрөнгийн 1-9 дүгээр саруудын нийт 132,982.4 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг тайлагнаагүй.	1	132,982.4	1	132,982.4			1	132,982.4		
2	Санхүүгийн үр дүнгийн болон мөнгөн гүйлгээний тайланд 164,250.4 мянган төгрөгийн орон нутгийн санхүүжилтийн орлогыг хандив тусламжийн орлогоор тайлагнасан	1	164,250.4			1	164,250.4	1	164,250.4		
3	Бараа материалын үнийн дүнгийн болон нэр төрлийн тайланг гаргаагүй, шаардах хуудсанд дарга, нягтлан бодогчийн зөвшөөрсөн гарын үсэг байхгүй, материал хүлээн авсан ажилтны гарын үсэггүйгээр 166,625.7 мянган төгрөгийн бараа материал зарлагдсан.	1	166,625.7			1	166,625.7	1	166,625.7		
4	Санхүүгийн үр дүнгийн тайланд 277.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 8,869.5 мянган төгрөгийн бага үнэтэй түргэн элэгдэх зүйл, 8,304.6 урсгал засварын материалыг тус тус нормын хувцас зөөлөн эдлэлийн зардалд тайлагнасан.	1	17,451.2			1	17,451.2	1	17,451.2		
5	Санхүүгийн үр дүнгийн тайланд 10,653.0 мянган төгрөгийн дотоод албан томилолтын зардлыг бусад зардлаар тайлагнасан.	1	10,653.0			1	10,653.0	1	10,653.0		
6	Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын Тамгын газраас санхүүжүүлсэн сургуулийн дотуур байрны уур сорогчийн Төв аймгийн орон нутгийн өмчийн газрын зөвшөөрөлгүй 13,614.0 мянган төгрөгийн хөрөнгийг сайжруулалтаар бүртгэсэн.	1	13,614.0			1	13,614.0	1	13,614.0		
7	Тайлант онд 884,169.4 мянган төгрөгийн цалин хөлс, урамшлын зардлыг цалингийн өглөг дансанд бичилт хийлгүй бүртгэсэн.	1	884,169.4			1	884,169.4	1	884,169.4		
	Дүн	7	1,389,746.1	1	132,982.40	6	1,256,763.7	7	1,389,746.1		

Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.	1						1					
2	Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 198 ширхэг 37,154.8 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй, холбогдох байгууллагад хүсэлт өгч шийдвэрлүүлээгүй байна.	1	-					1					
3	Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн "Хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 254 дүгээр тогтоолын дагуу тайланд онд суралцсан давхардсан 1-5 дугаар ангийн сурагчдын тоогоор 52,919 сурагчдад өдөр ногдох нормативаар тооцоход 132,297.5 мянган төгрөг, дотуур байранд байрладаг давхардсан тоогоор 19,408 сурагчдад ногдох нормативаар тооцоход 117,670.5 мянган төгрөгийг тус тус зарцуулахаас 231,036.6 мянган төгрөг зарцуулж 18,931.4 мянган төгрөгийг тус тус дутуу зарцуулсан.	1	18,931.4			1	18,931.4						
4	Боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр (81834), Хүүхэд хамгаалал хөтөлбөр (80233)-ийн бараа үйлчилгээний бусад зардлаас нийт 6,749.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн.	1						1					
5	Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж 83,917.7 мянган төгрөгийн ном, сурах бичгийг сэлбэг хэрэгслийн дансанд, сургалтын хэрэглэгдэхүүнд ашиглагдаж 71,689.4 мянган төгрөгийн материалын мал амьтад дансанд бүртгэсэн.	1						1					
	Дүн	5	18,931.4			1	18,931.4	4					

Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт 171 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 128 мэдээлэл, хугацаа хоцорч мэдээлсэн 17 мэдээлэл, байршуулаагүй 26 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулахаас зарлагын 289,766.0 мянган төгрөгийн 21 гүйлгээ хугацаа хоцорч, орлогын 3,186,175.9 мянган төгрөгийн 59 гүйлгээ, зарлагын 19,800.0 мянган төгрөгийн 1 гүйлгээ, эхний хагас жилийн санхүүгийн тайлан, өмнөх оны аудитын дүгнэлт болон шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэр эх хуулбарыг тус тус байршуулаагүй байна.	1	3,495,741.9			1	3,495,741.9		
Дүн	1	3,495,741.9			1	3,495,741.9		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Тайлант онд 68,666.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авалт хийхдээ тендер зарлаагүй шууд худалдан авалт хийсэн.	1	68,666.0					1	68,666.0
Дүн	1	68,666.0					1	68,666.0
Нийт дүн	1	3,564,407.9			1	3,495,741.9	1	68,666.0

Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 61-20810579-ТӨА-2026/222/НА-СТА-ТШЗ Зуунмод сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайланд онд суралцсан 1-5 дугаар ангийн сурагчдын үдийн хоол болон дотуур байранд байрладаг сурагчдын өдрийн хоолыг олгох батлагдсан нормативаас 18,931,400 (арван найман сая есөн зуун гучин нэгэн мянга дөрвөн зуун) төгрөгөөр дутуу зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.4-т "Орон нутгийн төсвийн суурь зарлагыг тооцоох аргачлал, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх үйлчилгээний стандарт, тэдгээрийн орцын болон төсвийн нормативыг Засгийн газар тогтооно", Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн "Хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 254 дүгээр тогтоолын 1-т "ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн хүүхдийн нэг өдрийн үдийн хоолны түүхий эдийн зардлыг 2.500 төгрөгөөр тогтоосугай", 2-т "Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдрах дунд болон ахлах ангийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 6.300 төгрөгөөр, бага ангийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 6.000 төгрөгөөр тус тус тогтоосугай" гэж заасныг мөрдөөгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-т "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан нормативын дагуу сурагчдын хоолны зардлыг тооцож олгох, зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газар-т ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Х.Энхтуяа, нягтлан бодогч А.Рагчаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ч.МӨНХТУЯА

Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 62-20810579-ТӨА-2026/222/НА-СТА-ТШЗ Зуунмод сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургууль нь тайлант онд нийт 171 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 128 мэдээлэл, хугацаа хоцорч мэдээлсэн 17 мэдээлэл, байршуулаагүй 26 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулахаас зарлагын 289,766.0 мянган төгрөгийн 21 гүйлгээ хугацаа хоцорч, орлогын 3,186,175.9 мянган төгрөгийн 59 гүйлгээ, зарлагын 19,800.0 мянган төгрөгийн 1 гүйлгээ, эхний хагас жилийн санхүүгийн тайлан, өмнөх оны аудитын дүгнэлт болон шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэр эх хуулбарыг тус тус байршуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-т "хариуцлагатай байх", Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1.5-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.10-т "Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь үнэн зөв байршуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газар-т ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Борнуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Х.Энхтуяа, нягтлан бодогч А.Рагчаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ч.МӨНХТУЯА

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn